



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, 31 06 12, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcsud.gov.mn, Вэбсайт: www.mcsud.gov.mn

2019.08.26 № 03/3252

танай _____-ны № _____-т

Барилгачдын баярын үйл ажиллагааны
бэлтгэл ажлыг хангуулах тухай

Монгол Улсад Барилгын салбар үүсч хөгжсөний 93 жилийн ой “Барилгачдын өдөр-2019” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг үүгээр хүргүүлж байна.

Тус арга хэмжээг 2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр Барилгачдын талбайд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Иймд дээрх арга хэмжээний хүрээнд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж ажиллахыг хүсье.

Холбогдох мэдээллийг: Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах мэргэжилтэн Д.Батзориг /76003333 (1151), 88083442/-той холбогдож авна уу.


Хавсралт хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН



151034787

БАТЛАВ:
 БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
 ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
 БИЧГИЙН ДАРГА  С.МАГНАЙСҮРЭН

**БАРИЛГЫН САЛБАРЫН 93 ЖИЛИЙН ОЙ, “БАРИЛГАЧДЫН ӨДӨР-2019”, НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ
 ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Хэзээ:		2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр, Баасан гараг	
Хаана:		Барилгачдын талбай	
ЦАГ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	БЭЛТГЭЛ АЖИЛ	ХАРИУЦАХ ЭЗЭН
09 ⁰⁰ – 10 ⁰⁰	Барилгын салбарын ахмадууд, зочид төлөөлөгчдийг угтаж авах	<ul style="list-style-type: none"> ✓ Зочдын орж ирэх, зураг авахуулах хаалгыг чимэглэн бэлтгэх, улаан хивс дэвсэх, угтагчид зогссон байна. ✓ Зочдыг бүртгэж, энгэрийн тэмдэг зүүж талбайн төвд зассан хүндэтгэлийн суудалд суулгана. ✓ Тайзан дээр Цэргийн дуу бүжгийн чуулгын үлээвэр найрал хөгжимчид байрласан байна. ✓ Дэлгэцээр шторк, болон хүндэт зочдын орж ирж байгаа үеийг харуулсан шууд бичлэг гарч байна. 	Зохион байгуулах ажлын хэсэг
10 ⁰⁰ – 10 ¹⁰	Нээлтийн ажиллагаа үйл	<ul style="list-style-type: none"> ✓ Дохио дуугарч, дэлгэцээр эхлэл шторк гарна. /2 минут/ ✓ Үндэсний урлагийн их театрын бүжигчид ёслолын бүжиг бүжиглэнэ. /5 минут/ ✓ Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын үлээвэр найрал хөгжимд ёслолын сүр жавхлантай ая эгшиглэхэд хөтөлөгч гарч ирнэ. ✓ Хөтөлөгч МУСГЗ Д.Цоодол баярын мэнд дэвшүүлж, хүндэт зочдыг танилцуулна. /3 минут/ 	Зохион байгуулах ажлын хэсэг
10 ¹⁰ – 10 ¹⁵	Нээж үг хэлнэ.	<ul style="list-style-type: none"> ✓ МУ-ын ЗГ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нээж үг хэлнэ. 	Ц.Баярбат

		✓ Цэргийн жагсаал тугуудыг бэлтгэн зогссон байна./5 минут/	Шүрэнцэцэг Зохион байгуулах ажлын хэсэг
10 ¹⁵ – 10 ²⁰	Туг өргөх ёслол, Төрийн дуулал	✓ БХБЯ-ы туг, /МБНХолбоо/-ны тугийг цэргүүд жагсаалаар алхан очиж тугийн өндөрлөгт байршуулахад салбарын төлөөлөл алхан очиж тугийг мандуулна. Монгол Улсын төрийн дууллыг ирсэн зочид босож хүндэтгэлтэйгээр дуулна. /5 минут/ <i>БХБЯ-ны тугийг өргөн мандуулах хүмүүс:</i> - БХБ-ын сайд Баделхан, - БХТ-ийн захирал Ц.Амарсанаа, - ОСНААУГ-ын дарга Ч.Мэндбаяр <i>МБНХолбооны тугийг мандуулах хүмүүс:</i> - ТББ-уудыг төлөөлж МБНХолбооны ерөнхийлөгч Б.Батбаатар - Ахмад үеийн төлөөлж Ахмадын холбооны тэргүүн Гавьяат Барилгачин Л.Тогтохбаяр, - Залуу үеийг төлөөлж ШУТИС-ийн БАС-ийн 1-р курсын оюутан	Зохион байгуулах ажлын хэсэг
10 ²⁰ – 10 ²⁵	Баяр хүргэж үг хэлнэ.	✓ УИХ, ЗГ-аас уригдан ирсэн зочид үг хэлэх буюу МУ-ын Ерөнхий сайдын мэндчилгээг уншиж сонордуулна. /5 минут/	
10 ²⁵ – 10 ³⁵	Урлагийн мэндчилгээ	✓ Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын гоцлол дуучин, МУГЖ Ө.Уянга, МУСТА Б.Гомбо-Очир нар “Хүний заяа” дуу дуулна. Дэлгэцээр салбарын үе үеийн сайдууд, алдартан гавьяатуудын зураг гарна. /5 минут/ ✓ Үйлсийн сайхан Улаанбаатар дууг дуурь бүжгийн эрдмийн театрын дуучид дуулна. /Дэлгэцээр Барилгын салбарт хэрэгжиж байгаа томоохон төслүүдийг харуулна. Тухайлбал Төв Цэвэрлэх Байгууламж, Ногоон нуурын нээлт, Баригдаж байгаа сургууль, цэцэрлэгүүд, Буянт-Ухаа орон сууцны хороолол, аймаг, орон нутагт хийж байгаа ажлууд гэх мэт/, /5 минут/	
10 ³⁵ -10 ⁵⁰	Шагнал гардуулах ёслол	✓ Амжилт бүтээл хөдөлмөр зүтгэлээрээ тэргүүлсэн шилдэг тэргүүний хүмүүсийг шагнаж урамшуулах, төрийн дээд шагнал, одон, медаль	Зохион байгуулах ажлын хэсэг

		гардуулах ёслол болно. Шагналыг БХБ-ын сайд болон хүндэт зочдын төлөөлөл гардуулна. /25 минут/	
10 ⁵⁰ -11 ⁰⁰	Урлагийн мэндчилгээ	✓ “Би Монгол хүн” дуу – ОХУ-ын Марийнскийн Их Театрын гоцлол дуучин, МУГЖ, Чингисхаан одонт Г.Ариунбаатар дуулна. Ард нь Барилгын салбарын түүхэн бүтээн байгуулалтын зургууд гарна. /10 минут/	Зохион байгуулах ажлын хэсэг
11 ⁰⁰ -11 ³⁰	Барилгын салбарын оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах ёслол	<ul style="list-style-type: none"> ✓ Топ-10 аж ахуйн нэгжид нэр дэвшигч компаниудыг танилцуулна. Хөтлөгч тухайн байгууллагуудын амжилт бүтээлийн товч танилцуулга мэдээллийг өгнө. ✓ Дэлгэцэнд шторк гарна. <p>Шилдэг аж ахуйн нэгжийг шалгаруулж шагналыг гардуулах хүмүүс:</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан 2. БХБ-ын дэд сайд Б.Мөнхбаатар 3. ГЗБГЗЗГ-ын дарга Ц.Ганхүү 4. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГазрын захирал Ц.Амарсанаа 5. Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-ын захирал Ж.Хичээнгүй 6. ОСНААУГ-ын дарга Ч.Мэндбаяр 7. Монголын барилгачдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч М.Батбаатар 8. Барилгын салбарын үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн Батцогт 9. 10. Барилгын салбарын ахмадын хорооны тэргүүн Л.Тогтохбаяр <p>Шилдгээр шалгарсан ААН-үүд дурсгалын зураг авахуулна.</p>	Зохион байгуулах ажлын хэсэг
11 ³⁰ -11 ³⁵	Барилгын салбарын оны шилдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тугийг Барилгачдын талбайд залах ёслол	<ul style="list-style-type: none"> ✓ Үлээвэр найрал хөгжимчид байрласан байна. ✓ Байгууллагуудын тугийг бэлтгэсэн байна. ✓ Аж ахуйн нэгжээ төлөөлж туг мандуулах хүнийг урьдчилан бэлтгэж нэрсийг хөтлөгчид өгсөн байна. / 5 минут/ 	Зохион байгуулах ажлын хэсэг
11 ³⁵ -11 ⁵⁰	Урлагийн мэндчилгээ	✓ Монголын барилгачдын сүлд дуу “Барилгачдын алдар” – ХХ зууны манлай Соёл-Эрдэнэ, Өргөө хамтлаг дуулна. Рольтой бүжигчид /каскад, кобинзонтой/ бүжиглэж байхад дэлгэцэн дээр орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын түүхэн зургууд гарна. /5 минут/	

		<ul style="list-style-type: none"> ✓ Бөмбөрийн тоглолт. Авьяаслаг Монголчууд шоуны Алтан баззерт оролцогч Дуулга барилгын материалуудаар хийсэн хөгжмийн зэмсгээр шоу үзүүлбэр үзүүлнэ /5 минут/ ✓ Хар сарнай хамтлаг, Амармандахын “Аз жаргал хүсье” Дуун дээр хүүхдүүд зочдод баярын мэндчилгээ бүхий захидлууд өгнө. /5 минут/ 	
11 ⁵⁰ -12 ⁰⁰	Төгсгөл	<ul style="list-style-type: none"> ✓ Хөтлөгч нээлтийн үйл ажиллагааг өндөрлүүлэхэд Цэргийн дуу бүжгийн чуулгын үлээвэр найрал хөгжимд Халуун элгэн нутаг дуу эгшиглэнэ. /10 минут/ ✓ Хүндэт зочид төлөөлөгчид Дурсгалын зураг татуулна. ✓ Үргэлжлүүлэн талбайг тойруулан зассан асруудад байрласан төрийн болон төрийн бус байгууллагууд, оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаатай танилцана. 	Зохион байгуулах ажлын хэсэг
12 ⁰⁰ -17 ⁰⁰	Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг	<ul style="list-style-type: none"> ✓ Тухайн байгууллага хуваарилсан асарт байрлаж үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилна.Төрөөс Баримталж буй бодлого, шийдвэр, холбогдох дүрэм журам, хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрүүд, үйл ажиллагааны мэдээлэл өгнө. ✓ Үйл ажиллагааныхаа талаар танилцуулга, товч тайлан мэдээллийг цаасан болон видео хэлбэрээр бэлтгэж болно. ✓ Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлдэг зарим үйлчилгээгээ үзүүлэх, бүртгэл мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна. <p>Оролцогч байгууллагууд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Барилга, хот байгуулалтын яам; ✓ Барилгын хөгжлийн төв; ✓ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар; ✓ “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ; ✓ Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар; ✓ Барилгын салбарын ТББ, мэргэжлийн холбоод; ✓ Барилгын салбарын 2019 оны шилдгээр шалгарсан аж ахуйн нэгж байгууллагууд. 	Зохион байгуулах ажлын хэсэг

14 ⁰⁰	"Барилга орон сууц-2019" олон улсын үзэсгэлэн яармаг /Тусгай хөтөлбөрөөр/	✓ Үзэсгэлэнгийн нээлтийн үйл ажиллагаа Мишээл экспод зохион байгуулагдана.	Зохион байгуулах ажлын хэсэг, Барилга.МН
------------------	---	--	--

Хянасан:

ББМУБХЗГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Гантулга

Боловсруулсан:

ББМУБХЗГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Батзориг

